

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ХОРШООДЫН 2008 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2008.05.12


Улаанбаатар хот

НЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААР

Тайлант улиралд Хорооны тогтоолоор 18 ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгож, харин □Далай арвижих□, □Үлэмж арвижих□ зэрэг ХЗХ-дын хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор нийт 197 ХЗХ-ны 2008 оны I улирлын санхүүгийн тайлан нэгтгэлд хамрагдах байсан ч 16 ХЗХ буюу нийт ХЗХ-дын 8.1 хувь нь санхүүгийн тайлангаа ирүүлээгүй тул 9 ХЗХ-ны тайланг өмнөх улирлаар нь нэгтгэлд хамрагдаж, 181 ХЗХ буюу нийт ХЗХ-дын 91.9 хувь нь зохих журмын дагуу санхүүгийн болон зохистой харьцааны тайланг ирүүлснээр нийт 190 ХЗХ буюу ХЗХ-дын 96.4 хувь нь санхүүгийн тайлан нэгтгэгдлээ.




Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хоршоодын тоо өмнөх мөн үеийнхээс 2.4 дахин нэмэгдсэн ба хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээр нь ангилахад дараах байдалтай байна.



Орон нутагт 88 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ХЗХ-дын 44.7 хувийг, тэдгээрийн нийт актив 5,644,406.00 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын активын 12.6 хувийг, нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл 4,402,901.05 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дуудын олгосон зээлийн 14.4 хувийг, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 3,326,192.97 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын хадгаламжийн 10.5 хувийг, нийт хувь нийлүүлсэн

хөрөнгө нь 1,293,042.26 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын 17.5 хувийг тус тус эзэлж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дыг байршлын хувьд авч үзвэл Орхон аймагт 16, Архангай аймагт 8, Өвөрхангай аймагт 7, Дархан уул, Завхан, Увс аймагт тус бүр 6, Баян-Өлгий, Дундговь, Дорноговь, Хөвсгөл, Хэнтий, Баянхонгор аймагт тус бүр 4, Өмнөговь аймагт 3, Дорнод, Булган, Төв, Сүхбаатар аймагт тус бүр 2, Говьсүмбэр, Ховд, Говь-Алтай, Сэлэнгэ аймгуудад тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа явуулж байна.



Тайлант улиралд ХЗХ-дын нийт гишүүдийн тоо 23,431 хүрсэн, харин орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-д 9,432 гишүүнтэй байгаа нь нийт гишүүдийн 40.3 хувийг эзэлж байна.

Хорооны 2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 164 дүгээр тогтоолоор зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоосны дагуу нийт 175 ХЗХ 2007 оны зохицуулалтын үйлчилгээний хөлс 26,654.9 мянган төгрөг төлсөн байна.

Судалгаанаас үзэхэд ХЗХ-дын олгож буй зээлийн хүүгийн түвшин дундажаар 2.8-5.0 хувь, хадгаламжийн хүүгийн түвшин дундажаар 1.5-2.5 хувь байна.

ХОЁР. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Тайлант улиралд ХЗХ-дын нийт орлого 2,856,709.7 мянган төгрөг ба нийт орлогын бүтэц дараах байдалтай байна. Үүнд:

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		/мянган төгрөгөөр/	
		Нийт дүн	Хувь
Хүүгийн орлого			
1	Хугацаандаа байгаа хүүгийн орлого	2,155,465.1	75.45%
2	Зээлийн нэмэгдүүлсэн хүү, алдангийн орлого	32,237.7	1.13%
3	Үнэт цааны хүүгийн орлого	16.4	0.00%
4	Банкинд байршуулсан харилцах, хадгаламжийн хүүгийн орлого	377,349.1	13.21%
5	Бусад байгууллагаас авсан хүүгийн орлого	2,073.4	0.07%
6	Санхүүгийн түрээсийн орлого	1,543.4	0.05%
7	Бусад хүүгийн орлого	4,062.9	0.14%
Үйл ажиллагааны бусад орлого			
8	Элсэлтийн хураамж	4,544.1	0.16%
9	Гишүүний татвар	6,040.8	0.21%
10	Үйлчилгээний хураамж	28,135.7	0.98%
11	Үйл ажиллагааны бусад орлого	45,538.1	1.59%
12	Ердийн бус орлого	1,874.7	0.07%
Үйл ажиллагааны бусад орлого			

15	Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын орлого	4,493.3	0.16 %
17	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	23,372.7	0.82 %
18	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	153,597.6	5.38 %
20	Бусад орлого	10,929.6	0.38 %
21	Онцгой шинжтэй орлого	5,435.1	0.19 %
Нийт орлого		2,856,709.7	100%

Нийт орлогын 75.5 хувийг зээлийн хүүгийн орлого эзэлж байгаа нь зээлийн үйл ажиллагааны орлого нь нийт орлогын гол эх үүсвэр болж байгааг илтгэж байна.

Харин банкинд байршуулсан харилцах, хадгаламжийн хүүгийн орлого нийт орлогын 13.2 хувийг эзэлж байгаа нь зээлийн эх үүсвэр хангалттай ч ХЗХ-д идэвхитэй зээлийн үйл ажиллагаа эрхлэхгүй, зээл гаргах боломж муу байгааг харуулж байна.

Нийт зардал 2,465,442.9 мянган төгрөгт хүрсэн ба нийт зардлын бүтэц дараах байдалтай байна.

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		<i>/мянган төгрөгөөр/</i>	
		Нийт дүн	Хувь
Хүүгийн зардал			
1	Хугацаагүй хадгаламжийн хүүгийн зардал	864,228.8	35.0%
2	Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал /1 жил хүртэлх хугацаатай/	732,369.6	29.7%
3	Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал /1 ээс дээш жилийн хугацаатай/	61,077.9	2.5%
4	Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	30,357.3	1.2%
5	Бусад хүүгийн зардал	1,255.2	0.05%
Болзошгүй эрсдэлийн сангийн зардал		86,006.6	3.5%
Үйл ажиллагааны зардал			
6	Боловсон хүчний зардал	298,627.5	12.1%
7	Бусад төрлийн зардал	315,724.1	12.8%
Үйл ажиллагааны бус зардал		21,819.9	0.9%
Татварын зардал		51,365.7	2.1%
Ердийн бус зардал		2,610.2	0.1%
НИЙТ ЗАРДАЛ		2,465,442.9	100%

Нийт зардлын 67.2 хувь нь хадгаламжийн хүүгийн зардал, 24.9 хувь нь үйл ажиллагааны зардал буюу боловсон хүчний холбогдолтой зардал байна.

Харин банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал 30,357.3 мянган төгрөг буюу нийт зардлын 3.5 хувийг эзэлж байгаа нь банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн нийт эх үүсвэрт эзлэх хувийн жин бага байгааг харуулж байна.

ХЗХ-дын үйл ажиллагааны цар хүрээ өргөжиж, нийт орлогын өсөлтийн хурдац, нийт зардлын өсөлтийн хурдацаас их байгаагаас нийт 391,266.8 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан байна.

Тайлант хугацаанд тодорхой хэмжээгээр ашигтай ажилласан 148 ХЗХ байгаа нь нийт ХЗХ-ны 77.9 хувийг эзэлж байгаа ба тэдгээрийн ашиг 306.0 төгрөгөөс 121,563.4 мянган төгрөгийн хооронд хэлбэлзэж, ашигтай ажилласан ХЗХ-дын арифметик дундаж ашиг 2,643.7 мянган төгрөг байна.

Харин 42 ХЗХ буюу нийт ХЗХ-дын 22.1 хувь нь 5,113.0 төгрөгөөс 62,019.6 мянган төгрөг хүртэл алдагдалтай ажилласан ба зарим шалтгааныг нь тодруулж авч үзвэл, үйл ажиллагааны зардал өндөр, зээлийн чанар муу /Грави, Фрейндс Инвест, Мон-Инвест, Дээд мандал/, зээлийн чанар муудсанаар эрсдлийн зардал өндөр байгаа /ОББТ, Орчил бизнес/, үйл ажиллагаа жигдрээгүй /Ю Эс Ди Эм, Баянцогт нуур/ зэргээс шалтгаалжээ.

ГУРАВ. АКТИВЫН ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1 Активын талаар

ХЗХ-дуудын тайлант улирлын нийт активын бүтэц дараах байдалтай байна. Үүнд:

ХӨРӨНГӨ	/мянган төгрөгөөр/	
	2008-I	Хувь
1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	43,337,758.42	96.70%
МӨНГӨН ХӨРӨНГӨ	11,134,968.00	24.85%
1.Касс дахь бэлэн мөнгө	12,173,465.20	27.16%
2.Банкинд байршуулсан харилцах	486,294.20	1.09%
3.Банкинд байршуулсан хадгаламж	9,426,297.70	21.03%
4.Бусад байгууллагад байршуулсан харилцах	5,029.50	0.01%
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	29,386,442.80	65.57%
5. Нийт зээл	30,602,751.80	68.29%
5.1.Хэвийн зээл	28,077,348.50	62.65%
5.2.Хугацаа хэтэрсэн зээл	1,223,284.30	2.73%
5.3.Чанаргүй зээл	1,302,118.90	2.91%
Хэвийн бус	309,541.50	0.69%
Эргэлзээтэй зээл	190,055.20	0.42%
Муу зээл	802,522.30	1.79%
5.4.(Зээлийн эрсдэлийн сан)	(1,216,309.10)	(2.71)%
АВЛАГА (ЦЭВРЭЭР)	2,388,771.40	5.33%
6. Байгууллага, хүмүүсээс авах авлага	399,040.60	0.89%
7. (Байгууллага, хүмүүсээс авах авлага эрсдлийн сан)	(29,387.80)	(0.07)%
8. Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	2,019,118.50	4.51%
БУСАД ХӨРӨНГӨ	95,087.70	0.21%
9. Материал үнэ бүхий зүйл	47,236.80	0.11%
10. Урьдчилж төлсөн зардал, тооцоо	22,286.90	0.05%
11. Бусад актив	25,564.00	0.06%
ӨМЧЛӨХ БУСАД ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	332,488.30	0.74%
12. Өмчлөх бусад хөрөнгө	333,855.80	0.74%
13. (Өмчлөх бусад хөрөнгийн эрсдлийн сан)	(1,367.50)	0.0%
2. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	1,478,082.66	3.3%
ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	1,336,820.30	2.98%
14. Үндсэн хөрөнгө	1,768,486.60	3.95%
15. (Үндсэн хөрөнгийн элэгдэл)	(431,666.30)	(0.96)%
БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	141,262.40	0.32%
16. Биет бус хөрөнгө	28,917.60	0.06%
17.Бусад	112,344.70	0.25%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (1+2)	44,815,841.09	100.0%

Мөнгөн хөрөнгө нийт активын 24.8 хувь буюу 11,134,968.00 мянган төгрөг, цэвэр зээл нийт активын 65.6 хувь буюу 29,386,442.83 мянган төгрөг, авлага 5.3 хувь буюу 2,388,771.42 мянган төгрөг, бусад хөрөнгө 0.2 хувь буюу 95,087.79 мянган төгрөг, өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө /цэврээр/ 0.7 хувь буюу 332,488.37 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 2.9 хувь буюу 1,336,820.27 мянган төгрөг, бусад эргэлтийн бус хөрөнгө 0.3 хувь буюу 141,262.38 мянган төгрөг байна.

Харин хүүгийн орлого авчирдаг активуудын дүн 30,607,780.8 мянган төгрөг болж нийт активт эзлэх хувийн жин нь 68.3 хувь байна.

3.2 Активын багцын чанар

Нийт олгосон зээлийн өрийн үлдэгдлийн бүтэц дараах байдалтай байна.

АКТИВ	/Мянган төгрөгөөр/	
	2008-I	Хувь
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	29,386,442.83	

Нийт зээл	30,602,751.89	100.0 %
1.Хэвийн зээл	28,077,348.55	91.7%
2.Хугацаа хэтэрсэн зээл	1,223,284.35	4.0%
3.Чанаргүй зээл	1,302,118.99	4.3%
<i>Хэвийн бус</i>	<i>309,541.49</i>	<i>1.0%</i>
<i>Эргэлзээтэй зээл</i>	<i>190,055.21</i>	<i>0.6%</i>
<i>Муу зээл</i>	<i>802,522.29</i>	<i>2.6%</i>
(Зээлийн эрсдэлийн сан)	(1,216,309.05)	4.0%

ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ТАЛААР

4.1 Нийт эх үүсвэрийн талаар

ХЗХ-дуудын тайлант улирлын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтэц дараах байдалтай байна.

<i>/мянган төгрөгөөр/</i>		
ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2008-1	Хувь
1. ӨР ТӨЛБӨР	35,776,261.44	79.83%
ХАДГАЛАМЖ	31,570,530.82	70.45%
1. Хугацаагүй	2,305,926.20	5.15%
2. Хугацаатай	29,264,604.62	65.30%
БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ	1,919,546.27	4.28%
3. Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээл	1,919,546.27	4.28%
БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,176,312.19	4.86%
4. Татварын төлөх өглөг	52,513.71	0.12%
5. Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	1,922,352.91	4.29%
6. Өглөг	80,593.57	0.18%
7. Бусад пассив	120,851.99	0.27
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	109,872.16	0.25%
8. Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээл	109,872.16	0.25%
2. ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	9,039,579.66	20.17%
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ	7,394,042.10	16.50%
9.Хувь нийлүүлсэн хөрөнгө	7,394,042.10	16.50%
ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ	1,645,537.56	3.67%
10.Нөөцийн сан	638,668.54	1.43%
11.Дахин үнэлгээний сан	20,465.33	0.05%
12.Нийгмийн хөгжлийн сан	102,842.28	0.23%
13.Бусад сангууд	152,716.06	0.34%
14.Хандив, тусламж	24,989.02	0.06%
15.Бусад өмч	(14,728.02)	0.0%
16.Тайлангийн үеийн ашиг/алдагдал	391,266.82	0.87%
17.Хуримтлагдсан ашиг/алдагдал	329,317.53	0.73%
ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ ДҮН (1+2)	44,815,841.09	100.0%

Тайлант хугацааны эцэст хугацаатай болон хугацаагүй хадгаламж нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн **79.8** хувийг **/31,570,530.82** мянган төгрөг/, хувь нийлүүлсэн хөрөнгө нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн **16.4** хувийг **/7,394,042.10** мянган төгрөг/ тус тус эзэлж байна.

Гишүүдээс хоршоонд хадгалуулсан мөнгөн хадгаламжийн нийт дүн нь нийт өр төлбөрийн 88.2 хувьтай, харин нийт активын 70.5 хувьтай тэнцүү байгаа нь нийт өр төлбөрийн 90-ээс дээш хувь, нийт активын 70 хүртэлх хувь байх зохистой харьцааны үзүүлэлтийг хангахгүй байна. Энэ нь гишүүдийн хадгаламжийг эрсдэлд оруулж болзошгүй байна.

Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээл нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн 4.3 хувь байгаа бөгөөд энэ нь зөвхөн зээл авсан 37 ХЗХ буюу нийт ХЗХ-дын 18.8 хувьд нь хамаатай байна. Энэ нь нийт ХЗХ-дын хэмжээнд банк, санхүүгийн байгууллагаас санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх явц нь зохистой бус түвшинд байгааг харуулж байна гэж дүгнэлээ.

ТАВ. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР

ХЗХ-дын санхүүгийн нэгтгэлийн хувьд Хорооны 2007 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоож, хяналт тавих журам”-ын тогтоосон зохистой харьцаа дараах байдалтай байна.

	ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ТАЙЛАНГААР
Х	АКТИВ ХӨРӨНГИЙН ХАМГААЛАЛТ	
1	ОРЛОГО ОРУУЛДАГ АКТИВЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (80 Хувиас дээш)	80.0% 87.5%
2	ТӨЛБӨРИЙН ЧАДВАР (110 хувиас дээш)	110.0% 125.3%
С	ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ	
1	КАСС ДАХЬ БЭЛЭН МӨНГӨНИЙ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (2 хүртэлх хувь)	2.0% 2.7% ХАНГААГУЙ
2	ЗАСГИЙН ГАЗАР, ТӨВ БАНКНЫ ҮНЭТ ЦААС (10 хувиас хэтрэхгүй)	10.0% 0.0%
3	ӨБҮХХ-ИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас хэтрэхгүй)	5.0% 0.7%
4	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас хэтрэхгүй)	5.0% 3.0%
5	ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА - I (70 хүртэлх хувь)	70.0% 70.4% ХАНГААГУЙ
6	ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА - II (90 хувиас дээш)	90.0% 88.2% ХАНГААГУЙ
7	БУСДААС АВСАН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас хэтрэхгүй)	5.0% 4.5%
8	ГИШҮҮДИЙН ХНХ-ИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА - I (2 хувиас дээш)	2.0% 16.5%
9	ГИШҮҮДИЙН ХНХ-ИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА - II (30 хувиас доош)	30.0% 81.8% ХАНГААГУЙ
10	ХОРШООЛОГЧДЫН ӨМЧИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас дээш)	5.0% 3.7% ХАНГААГУЙ
11	НӨӨЦИЙН САНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (40 хувиас дээш)	40.0% 38.8% ХАНГААГУЙ
Ч	АКТИВЫН ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ	
1	НИЙТ АКТИВ ХӨРӨНГӨД ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ (70-80 хүртэлх хувь)	80.0% 68.3% ХАНГААГУЙ
2	ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ (5 хувиас хэтрэхгүй)	5.0% 2.9%
З	ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ	
1	ЗЭЭЛИЙН БАГЦЫН ӨГӨӨЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (Зах зээлийн хувиас бага)	- 2.4%
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ТҮВШИН (5 хувиас бага)	5.0% 1.4%
3	НЭГ ГИШҮҮНИЙ ОРУУЛАХ ХУВЬ ХӨРӨНГИЙН ХЯЗГААР (төгрөгөөр, дундаж хэмжээний 200 хувиас ихгүй)	631,133.29 -
Т	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР	
1	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА (15 хувиас дээш)	15.0% 31.1%
Ө	ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ (ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ)	
1	АКТИВЫН ӨГӨӨЖ	3.3%
2	ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ	3.5%
3	ЗЭЭЛИЙН БАГЦЫН ӨГӨӨЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	4.8%

ЗУРГАА. ДҮГНЭЛТ

ХЗХ-дын нийт актив 2008 оны I улирлын байдлаар 44,815,8 сая төгрөг байгаа нь банкны салбарын нийт активын **/банкны салбарын нийт актив 3,485,730.3 сая төгрөг/** 1.3 хувьтай, нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл 30,602.7 сая төгрөг байгаа банкны салбарын нийт олгосон зээлийн **/2,366,511.0 сая төгрөг/** 1.3 хувьтай, нийт хадгаламжийн үлдэгдэл 31,570.5 сая төгрөг байгаа банкны салбарын нийт хадгаламжийн **/1,633,376.9 сая төгрөг/** 1.9 хувьтай тус тус тэнцэж байна.

Тайлант улиралд 69 ХЗХ нөөцийн болон нийгмийн хөгжлийн сан байгуулаагүй байна.

Нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл нийт активын 68.3 хувь, харин мөнгөн хөрөнгө нийт активын 24.9 хувь байгаа нь цаашид зээл олголтыг нэмэгдүүлэх боломжтойг харуулж байна. Гэвч нийт эх үүсвэрийн 70.5 хувийг гишүүдээс татан төвлөрүүлсэн хадгаламжаар бүрдүүлсэн нь олгосон зээлийн хэмжээг нэмэгдүүлэхгүй бол алдагдалд орж болзошгүй гэдэг нь харагдаж байна.

Хувь нийлүүлсэн хөрөнгө нь цөөхөн тоотой гишүүдэд төвлөрөлтэй ХЗХ-дын хувьд өөрийн хөрөнгөөр төдийгүй бусдаас санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх замаар үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн тулд банк, санхүүгийн байгууллагаас зээл авах, төсөлд хамрагдах, санхүүгийн эх үүсвэр татах асуудлыг сонирхож байгаагаас нийт эх үүсвэрийн хэмжээ цаашид өсч ББСБ болох хандлагатай нь ажиглагдаж байна. /Жишээлбэл “Очир ундрааа инвест”, “Мэлсэн”, “Аврагас зоос”/

ХЗХ-д бичил банкны үүргийг гүйцэтгэж байгаагаас санхүүгийн зуучлалыг өргөжүүлэх, мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, шударга өрсөлдөөнт орчныг бий болгох арга хэмжээ авах, олон улсын стандартын дагуу сонгодог утгаар нь гүнзгийрүүлэн хөгжүүлэх зэрэг зорилтууд нь санхүүгийн салбар дахь эрсдлийг бууруулах асуудалтай нягт холбоотой учир хууль, журмыг тодорхой нэг мөр ойлголттой болгох шаардлага тавигдаж байна.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР